

**8.4.26 Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдлын хэрэгжилт, явц, үр дүн**

Япон Улсын Элчин Сайдын Яам "Өвсний үндэс" хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 1 дүгээр сургуулийн засварын ажлын гүйцэтгэл, үр дүн

## Бүлэг 1

### Засварын ажлын санхүүжилт гэрээний дагуу хийгдсэн эсэх

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 1-р сургуулийн засварын ажил гүйцэтгэх гурван талт гэрээг 2022 оны 09 сарын 05-ны өдөр Сэлэнгэ аймгийн ЗДТГ ХБТХО хэлтэс /захиалагч/, Сүхбаатар сумын 1-р сургууль /ашиглагч/, "Оргил таур" ХХК/ гүйцэтгэгч/ гурвын хооронд байгуулсан байна.

Уг гэрээнд санхүүжилтийн нөхцөлийг дараах байдлаар тодорхойлсон байна.

Гэрээний 4.1 /Санхүүжилтийн нөхцөл/

д/д	Үзүүлэлт	Хувь	Дүн /төгрөгөөр/	Санхүүжилт авсан он сар өдөр
1	Нэгдүгээр санхүүжилт	40%	267,725,855=00	2023-10-05
2	Хоёрдугаар санхүүжилт	30%	200,794,391=00	2023-10-27
3	Улсын комисст хүлээлгэн өгсөний дараа	30%	200,794,391=00	
	Нийт дүн		669,314,637=00	

Гэрээт ажлын 70% буюу 468,520,246=00 төгрөгийн санхүүжилт олгогдсон байна.

Гэрээний дагуу 30 хувийг гүйцэтгэсний дараа олгохоор хийгдсэн байна.

## Бүлэг 2

### Засварын ажил захиалагчийн шаардлагыг хангахуйц чанартай сайн хийгдсэн эсэх

Засварын ажлыг Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын "ГХБХБГазар"-ын БХБ хэлтсийн ахлах мэргэжилтэн, хяналтын инженер О.Баярхүү, зураг төсвийн зохиогч "Талхун Арал" ХХК-ны захирал Ч.Наранцогт, Сэлэнгэ аймгийн Ерөнхий боловсролын 1-р сургуулийн захирал Ц.Ренченноров, сургалтын ерөнхий менежер Н.Дэлгэрцэцэг, цахилгаанчин Б.Юндэнбат, сан техникийн слесерь Д.Оргил нар ажлын явцад хяналт шалгалт хийж тухай бүр дүгнэлт гаргаж байсан байна.

Үүнд: Барилга байгууламжийн мэдээлэл :

Ерөнхий боловсролын 1-р сургуулийн барилга нь Дотуур байр бүхий /3 давхар/, П хэлбэрийн 3 давхар бүхий угсармал хийцтэй барилга болно.

Сургуулийн барилга -3 давхар 50,520м х 60,0 м

Дотуур байр - 3 давхар 54,0м х15,0 м

#### 1. Цахилгааны ажил

- Сургуулийн барилгын 1,2,3, давхаруудын гэрэлтүүлгийн хуучин самбарыг шинээр сольсон. Нийт 17ш
- Гаднаас орсон хувиарлах байгууламжийн самбар 3ш-ийг иж бүрэн сольсон.
- Далд суулгаж угсардаг разетик 112ш /хамгаалттай/
- Далд угсарсан унтраалга 115ш
- Аваарын гэрэлтүүлэг, гарцны тэмдэглэгээг шинээр суулгасан 29ш
- Бүх хүчит төхөөрөмжүүдийг газардуулгатай холбосон.
- Гадна 2 хаалганы дээр цахилгаан агааржуулах халаагуурыг шинээр суурьлуулсан.
- Гал тогооны хоол бэлтгэлийн өрөөний вентилятор 1ш суурьлуулсан.
- Спорт заалны гэрэлтүүлгийг сольсон 24 ш
- Салхивчны агаар сэлгэлтийн агергат суурьлуулсан 5ш
- Удирдлагын самбарыг хананд суурьлуулсан 5ш
- Дотуур байрны гал тогоо руу тэжээл татсан /16мм х 4 огтлолтой зэс зөөлөн утсаар 132 м кабель татсан/
- Зоорийн давхарын гэрэлтүүлэг /1х2,5/ огтлолтой зэс голтой порвод утсаар 819м, 80 ш ус чийгний хамгаалалттай гэрлийг суурьлуулж, 3 ш автомат унтраалга /1,6 кв/, ус чийгний хамгаалалттай 7ш разетик,



## 2. Үзель ажил

- Ус чийгний хамгаалалттай гэрэл 8ш
- Унтраалга, разетик тус бүр 2, 2 ш-ийг 1х2,5 –ийн огтлолтой 50 м зэс голтой утсаар холбосон

## 3. Газардуулга

- Барилгын дээврийн хэсгүүдэд 10 диаметртай цайрдсан ган кругээр дээврийг бүтэн торлож, хөндийрүүлэгч дэрэн дээр угсарсан.
- Дээврээс барилгын ханыг дагуулж 5 см өргөнтэй хавтгай цайрдсан төмрөөр газрын гадаргууруу холбож,  $\Phi$  0,22 см зэс гадсыг зургийн дагуу гадаслан зоосон. Омын хэмжилт хийлгэсэн байна.
- Урлаг зааланд 1х2,5 утсаар 190 м зэс голтой утсаар тайзны гэрэлтүүлэгийн монтаж хийсэн.
- Урлагийн заалыг тойруулж шар өнгийн туузан гэрэл байршуулсан
- 3 талын хана луу туссан гоёлын лед гэрэл байршуулсан
- Тус бүрд нь унтраалга тавьж өгсөн.

## 4. Барилгын зураг төслийн дагуу галын хайрцаг

- Галын хайрцгийг давхар бүрт суулгасан. 16 ш

## 5. Заслын ажил /ариун цэврийн өрөө/

- 889.2 м<sup>2</sup> ханыг 30х60 харьцаатай цайвар болон цайвар саарал өнгийн плита хослуулан хананд нааж, 150 м<sup>2</sup> шалыг 60х60 саарал өнгийн плита наасан.
  - Шаргал өнгийн хар оруулгатай модон хаалгыг цоожны хамт 34 ш
  - Хөнгөн цагаан рамтай 50х60 дүүжин тааз 150 м<sup>2</sup> –ийг угсарсан.
  - Судалтай цайвар шаргал өнгийн гипсэн хавтангаар ариун цэврийн өрөөнүүдийн тусгаарлах хана хаалгыг төмөр тоноглолоор тоноглон хана шалтай бэхэлж суурьлуулж өгсөн.
  - Ариун цэврийн өрөөний суултуур 45 ш
  - Ариун цэврийн өрөөний шаазан угаалтуур 72ш /багш нарын өрөөнд 1 угаалтуур тавьж өгсөн байна./
  - Зураг төсөлд заасны дагуу шинээр гэрэлтүүлэг суулгасан.
  - Ариун цэврийн өрөөний бүх цэвэр усны шугамууд /босоо болон хэвтээ/, бүх бохирын шугам /босоо болон хэвтээ/,
  - трапны шугам сольж хийж гүйцэтгэсэн байна.
- Нийт 12 ариун цэврийн өрөө, 2 ш дүүшний өрөөг бүрэн засварлаж шинэчилсэн.

## 6. Цэвэр, бохир усны шугам

- Бүх анги, коридорын цэвэр болон бохирын шугамыг бүрэн шинэчилсэн. Бохир шугам ф 50мм 692м, цэвэр усны шугам ф15 аас ф25 мм-ын голчтой шугам хоолойг 1170м, ф32 д-ийн голчтой 143м, ф50 голчтой 221 м, ф 80-150 - ийн голчтой 225 м, нийт 180 ш 15-25 д-ийн хэмжээтэй винтель, хаалтууд, ф32-40 мм 6 хаалт; 26 ш хий авагч, цэвэр усны шугамын 560 м дулаалга хийгдсэн байна.
- Зоорийн давхарын цэвэр усны 560м ф50х150 -ийн хэмжээтэй цайрдсан ган трубагаар цэвэр усны шугамуудыг бүрэн шинэчлэн хийсэн байна.
- Бохир усны 692 м ф50-150 -тай хуванцар хоолойгоор босоо шугам болон эргэлтийн бүх өнцгүүдийн хажууд аваарын шалгах ревит хийж өгсөн.

## 7. Бойлурын ажил

- Бойлурын өрөөнд үзелээс халаах тэжээлийн шугам татаж ф25- ийн ган трубагаар халаалт өгөх буцах шугам татаж зургийн дагуу регистер гагнан суурьлуулж хийж гүйцэтгэсэн байна.

## 8. Магадлашгүй ажил

Тус сургуулийн засварын ажлыг гүйцэтгэх явцад батлагдсан төсөвт тусгагдаагүй зайлшгүй хийгдэх магадлагшгүй ажлыг

Захиалагч байгууллага : Сэлэнгэ аймгийн ЗДТГ

Гүйцэтгэгч байгууллага: "Оргил таур" ХХК

Зураг төсвийг зохиогч байгууллага: Талхун арал" ХХК-ийн төөлөлүүд

хэллцэж 2023 оны 11 сарын 13-ны өдөр актаар магадлагшгүй ажлын зардлыг санхүүжүүлэх зардлыг ажлын төсөв өртөгт багтаан сахүүжүүлэхээр болсон байна.

Магадашгүй ажлын төсөвын дүнг хавсарт № 2-т аудит хийсэн болно.

## 9. Гадна хаяг хийлгэсэн байсан

10. Барилгын засварын ажлын чанарт " Оргил таур "ХХК 2022- оны 12 сарын 20- нөөс Монгол улсын барилгын тухай хуулийн 14,3-д заасны дагуу барилга байгууламийг ашиглалтанд зүгширүүлэх, тохируулах хугацаа 1 жил, барилга байгууламжийг зүгширүүлэх, тохируулах хугацаа дуусгавар болсноос хойш гүйцэтгэгч нь гүйцэтгэсэн ажилдаа гэрээнд заасаны дагуу 3 жилийн баталгаат хугацаа гаргаж өгсөн байна



## Бүлэг 3

### Барилгын засварын ажил гэрээнд заасан хугацаанд хийгдсэн эсэх

Засварын ажлыг дараах байдлаар тусгажээ.

№	Үзүүлэлт	Гэрээ хийсэн огноо	Гүйцэтгэлээрхи огноо
1	Ажил эхлэх хугацаа	2023-08-25	2023-08-25
2	Ажил дуусах хугацаа	2023-10-20	2023-11-13

Засварын ажлыг Сэлэнгэ аймгийн "Газрын харилцаа барилга хот байгуулалтбн газар" ОНӨААТҮГазартай гэрээ хийж ажил эхлэх зөвшөөрлийг авч ажлыг эхлүүлсэн байна.

"Оргил таур" ХХК нь Японы Элчин Сайдын Яам "Өвсний Үндэс" Хөтөлбөрийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 7-р баг Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн засварын ажлыг 2023 оны 08 дугаар сарын 25-ны өдөр эхлэж, зураг төсвийн дагуу ажлыг гүйцэтгэж 2023 оны 11 сарын 08-нд дуусгаж гэрээний хугацаанаас 18 хоног хэтрүүлэн гүйцэтгэсэн байна.

Энэ нь тус сургуулийн захирлын 2023 оны 09 сарын 07-ны 170/1 тоот хүсэлтийн дагуу /Хэсэгчилсэн засварын ажил хийж байгаа үед дуу чимээ, тоосжилт их байгаа нь сурагчдын анхааралд болон хичээлэлтэнд сөргөөр нөлөөлж байна гэсэн хүсэлт/ хичээлийн бус цагаар засварын ажлыг хийж гүйцэтгэсэн нь нөлөөлсөн байна.

Иймээс улсын комисс ажиллах хугацаа хойшлогдож 2023 оны 11 сарын 13-нд улсын комисс хүлээн авсан байна.

## Бүлэг 4

### Төсвийн хэрэгжилтийн бодит байдалд үнэлэлт дүгнэлт өгөх

**4.1** Төсөвт өртөг нь хяналтын төсөвт тусгагдсан ажлын тодорхойлолт, тоо хэмжээнээс зөрүүтэй эсэх

Захиалагчийн ажлын тодорхойлолт, гүйцэтгэгчийн ажлын тоо хэмжээ зөрүүтэй байгаа эсэхийг шалгахын тулд нэгдсэн товчоо болон зардал бүрийн төсөвт өртгийг хяналтын төсөвтэй тулган харьцууллаа.

Төсөвт өртгийг 669,314,637/ зургаан зуун жаран есөн сая гурван зуун арван дөрвөн мянга зургаан зуун гучин долоон/ төгрөгөөр гүйцэтгэх боломжтой гэж үзсэн байна. Хавсралт / №1/

**4.2** Засварын ажил нь төсвийн дагуу хийгдсэн эсэх

Засварын ажил нь төсвийн дагуу хийгдсэн эсэхийг гүйцэтгэлийн төсвийг батлагдсан төсөвтэй харьцуулах замаар судалж үзлээ.

Судалгаанаас харахад гүйцэтгэлийн тоо хэмжээ нь батлагдсан төсөвт тусгагдсан тоо хэмжээ, төсөвт өртгийн хувьд зөрүүгүй байна.

Барилгын засварын ажлыг 70 хувь гүйцэтгээд 468,520,245 төгрөгийн гүйцэтгэлийн төсөв гарган хянуулж санхүүжилт авсан.

Нийт 669,314,637 төгрөгийн төсөвт өртөгтэйгээр уг ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

**4.3** Нягтлан бодох бүртгэлийн хөтлөлтийн талаар

"Оргил таур" ХХК-ийн төсвийн гүйцэтгэлийг анхан шатны нягтлан бодох бүртгэлийн баримтыг шалгахад НББОУС-ийн дагуу бүртгэсэн байна.

## Бүлэг 5

### ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

Аудитын явцад олж бүрдүүлсэн нотлох зүйлс, баримт материал, хийсэн ажиглалт, судалгаанд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

#### ДҮГНЭЛТ:

Бидний дүгнэлтээр Япон Улсын Элчин Сайдын Яам "Өвсний үндэс" хөтөлбөрийн хүрээнд санхүүжигдсэн Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 1 дүгээр сургуулийн засварын ажлын төсөл амжилттай хэрэгжсэн байна.

Уг төсөвт ажлыг Улаанбаатар хотын Баянзүрх дүүрэг 5 дугаар хороо "Оргил таур" ХХК нь 100 хувь буюу 669,314,637 /зургаан зуун жаран есөн сая гурван зуун арван дөрвөн мянга зургаан зуун гучин долоон / төгрөгийн төсөвт өртөгтэйгээр чанартай сайн гүйцэтгэн ашиглалтанд хүлээлгэн өгсөн байна.

#### ТАЙЛАН БИЧСЭН

ЗАХИРАЛ

АУДИТОР

АУДИТОРЫН ТУСЛАХ



Ч.ЦЭРЭННАДМИД

Ш.ГАНЧИМЭГ

Г.УРАНЧИМЭГ

Л.ОДОНЧИМЭГ



Япон Улсын Элчин Сайдын яам "Өвсний үндэс" хөтөлбөрийн  
хүрээнд хийгдсэн Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр  
сургуулийн засварын ажлын гүйцэтгэл, үр дүн

Хавсралт №1

Барилгын засварын ажлын төсөвт өртгийг гүйцэтгэлтэй нь харьцуулсан судалгаа

2023-11-08

/төгрөгөөр/

№	Зардлын нэр	Төсөвт өртөг	Ажлын гүйцэтгэл	Аудитлагдсан дүн
1	Цалин	173,206,069	173,206,069	173,206,069
2	Материал	288,220,849	288,220,849	288,220,849
3	Тээвэр	8,643,423	8,643,423	8,643,423
4	Машин ашиглалт	8,696,086	8,696,086	8,696,086
	<b>Шууд зардлын дүн</b>	<b>478,766,427</b>	<b>478,766,427</b>	<b>478,766,427</b>
5	Нэмэгдэл зардал /86,5%/	53,979,228	53,979,228	53,979,228
6	Ашиг 15%	79,911,848	79,911,848	79,911,848
	<b>Барилга угсралтын ажлын дүн</b>	<b>612,657,503</b>	<b>612,657,503</b>	<b>612,657,503</b>
7	НӨАТ 10%			
8	Нормчлолын сан 0,18%	1,102,784	1,102,784	1,102,784
	<b>ДҮН</b>	<b>613,760,287</b>	<b>613,760,287</b>	<b>613,760,287</b>
9	Захиалагчийн албаны зардал	12,253,150	12,253,150	12,253,150
10	Инженер, хайгуул, зураг төслийн ажлын дүн	24,921,476	24,921,476	24,921,476
11	Зураг төслийн зохиогчийн хяналтын зардал	6,126,575	6,126,575	6,126,575
	<b>ДҮН</b>	<b>657,061,488</b>	<b>657,061,488</b>	<b>657,061,488</b>
12	Магадлашгүй ажлын зардал /2%/	12,253,150	12,253,150	12,253,150
13	Бусад нэмэлт зардал	-	-	-
	<b>НИЙТ ДҮН</b>	<b>669,314,637</b>	<b>669,314,637</b>	<b>669,314,637</b>
		<b>100%</b>	<b>100%</b>	<b>100%</b>

"ЦЭСБ АУДИТ" ХХК

ЗАХИРАЛ  
АУДИТОР  
АУДИТОРЫН ТУСЛАХ



Ч.ЦЭРЭННАДМИД  
Ш.ГАНЧИМЭГ  
Г.УРАНЧИМЭГ  
Л.ОДОНЧИМЭГ

Япон Улсын Элчин Сайдын яам “Өвсний үндэс” хөтөлбөрийн  
хүрээнд хийгдсэн Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр  
сургуулийн засварын ажлын гүйцэтгэл, үр дүн

Хавсралт №2

Барилгын магадлашгүй ажлын гүйцэтгэлийг харьцуулсан судалгаа

2023-11-13

/төгрөгөөр/

№	Зардлын нэр	Ажлын гүйцэтгэл	Аудитлагдсан дүн	Зөрүү
1	Ажиллах хүчний зардал	6,145.710	6,145.710	-
2	Материалын зардал	5,275.744	5,275.744	-
3	Тээврийн зардал	261.736	261.736	-
4	Механизмын зардал	569.960	569.960	-
	Шууд зардалын дүн	12,253.150	12,253.150	-
5	Нэмэгдсэн өртөгийн зардал	0	0	-
	<b>Магадлашгүй ажлын зардалын нийт дүн</b>	<b>12,253.150</b>	<b>12,253.150</b>	-

**Нээлттэй мэдээллийг дэлгэрүүлж авах, тодруулах эрх бүхий ажилтан:  
Аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын  
хэлтсийн мэргэжилтэн С.Өлзийбүрэн 95629909**